***О.Намсрайжав*** *- Хууль сахиулахын удирдлагын академийн 821 дүгээр дамжааны суралцагч*

# ОРОН НУТГИЙН ШҮҮХИЙН шинжилгээний БАЙГУУЛЛАГЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ, ТУЛГАМДАЖ БАЙГАА ЗАРИМ АСУУДАЛ

***Товч агуулга.*** *Шүүхийн шинжилгээний байгууллагын чиг үүрэг, тогтолцоо, бүтэц, орон нутгийн Шүүхийн шинжилгээний байгууллагуудын өнөөгийн байдал, үйл ажиллагаанд тулгамдаж буй зарим асуудлыг танилцуулахад оршино.*

***Түлхүүр үгс:*** *Шүүхийн шинжилгээний алба, хэргийн газрын үзлэг, криминалистик, шинжлэн магадлахуй*

Түүхийн хөгжлийн бүхий л үе шатанд дэлхийн улс, гүрнүүд гэмт хэрэг, түүний шалтгаан нөхцлийг олж тогтоох, гэмт этгээдийг шинжлэх ухааны үүднээс хөдлөшгүй баримтаар нотлон тогтооход чиглэсэн судалгааг тасралтгүй явуулж ирсэн бөгөөд энэ нь одоогийн гэмт хэрэгтэй тэмцэх, илрүүлэх, нотлох мөрдөн шалгахад чиглэсэн орчин үеийн салбар шинжлэх ухааны хөгжлийг тодорхойлж, улмаар мэдлэгийн тусгай салбар криминалистик, криминологи, эрүүгийн байцаан шийтгэх эрх зүй зэрэг салбар шинжлэх ухааны онолын үндэс, суурь болж байна.

Хүний эрх, эрх чөлөөг дээдлэх зарчмыг дагах болсон одоогийн нийгэмд гэмт хэргийг илрүүлэх, буруутныг олж тогтооход шинжлэх ухааны тусгай мэдлэг, тогтсон арга зүйг ашиглах эрэлт хэрэгцээ, шаардлага өсөн нэмэгдсээр байна.

Монгол Улсын Их Хурлын 1998 оны 18 дугаар тогтоолоор батлагдсан “Монгол Улсын эрх зүйн шинэтгэлийн хөтөлбөр"-ийн 44 дүгээр зүйлд “хэрэг бүртгэх, мөрдөн байцаах, шүүх прокурор болон хууль сахиулах бусад байгууллагатай ажлын нягт уялдаа холбоотой криминалистик, шүүх-эмнэлэг, санхүү нягтлан бодох бүртгэл зэрэг шинжилгээний байгууллагын бүтэц, зохион байгуулалтыг хянан үзэж, нэгдсэн зохион байгуулалтад оруулан материаллаг баазыг нь бэхжүүлэх арга хэмжээ авна" гэж заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газрын 2005 оны 3 дугаар сарын 23-ны өдрийн 63 дугаар тогтоолоор Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд Шүүхийн шинжилгээний үндэсний төвийг байгуулсан.[1]

[1] http://www.nifs.gov.mn/

Монгол Улсын Засгийн газрын 2007 оны 10 дугаар сарын 17-ны өдрийн хуралдаанаар Аймаг, нийслэлийн цагдаагийн газар, хэлтсийн криминалистикийн шинжээч, нэгдсэн эмнэлгийн эмч нарыг нэгтгэн "Аймаг. нийслэлийн шүүхийн шинжилгээний алба байгуулах тухай 270 дугаар тогтоол" гарч, 2009 оны 01 дүгээр сарын 01-ээс орон нутагт аймаг, нийслэлийн Шүүхийн шинжилгээний албад байгуулагдан үйл ажиллагаа явуулж эхэлсэнээр орон нутагт шинжлэх ухааны үндэслэлтэй хэргийг нотлох үйл ажиллагаа хараат бус болж гэмт хэрэгтэй тэмцэх салбарт нэгэн шинэ хуудсыг нээсэн гэж үзэж болох юм.

Энэ хугацаанд гэмт хэргийн гаралт төв орон нутагт жил ирэх тусам ихсэж шинжилгээ хийлгэх байдал нэмэгдэж ажлын ачаалал ихтэй бүтэц орон тооны хувьд хүрэлцээгүй анх байгууллагдсан бүтцээр үйл ажиллагаа явуулж байгаа нь өнөөгийн тулгамдсан асуудал болж байна. Тухайлбал:

*Шүүхийн шинжилгээний байгууллагад хийсэн шинжилгээний тоон ¿ç¿¿ëýëò èéã 2009-2016 он хүртэл жилээр харьцуулсан хүснэгт*

| д/д | Шинжилгээний чиглэл | 2009 | 2010 | 2011 | 2012 | 2013 | 2014 | 2015 | 2016 |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | Êðèì èí àëèñòèêèéí Ø èí æèëãýýí èé ÷èãëýëýýð | 5766 | 6136 | 6117 | 7441 | 8032 | 10085 | 12641 | 14622 |
| 2 | Õèì è, ôèçèê, áèîëîãè, ÄÍ Õ, áàêòåðèîëîãèéí ø èí æèëãýýí èé ÷èãëýëýýð | 11505 | 10869 | 12400 | 12029 | 11629 | 13551 | 13894 | 13224 |
| 3 | Ø ¿¿õ ýì í ýëãèéí Ø èí æèëãýýí èé ÷èãëýëýýð | 27496 | 29049 | 31941 | 36151 | 38103 | 41242 | 42294 | 40423 |
| 4 | Ø ¿¿õ ýäèéí çàñãèéí ø èí æèëãýýí èé ÷èãëýëýýð | 121 | 143 | 141 | 278 | 216 | 240 | 291 | 256 |
| 5 | **Нийт** | **44888** | **46197** | **50599** | **55899** | **57980** | **65118** | **69120** | **68525** |

Төрийн тусгай чиг үүргийн хүрээнд "Шинжлэх ухааны тодорхой салбарын шинжилгээ судалгааны онол арга барилд түшиглэн хэргийн газрын үзлэгийг мэргэжлийн өндөр түвшинд зохион байгуулж ул мөр, эд мөрийн баримт цуглуулах, хэргийн холбогдох ул мөр, эд мөрийн баримт материалуудад өндөр технологи бүхий лабораторийн техник хэрэгсэл ашиглан шүүх, прокурор, хэрэг бүртгэх, мөрдөн байцаах байгууллагаас ирүүлсэн тогтоол, захирамж, эрх бүхий байгууллагын хүсэлтийн дагуу шинжилгээ хийж, шинжлэх ухааны үндэслэлтэй үнэн зөв дүгнэлт гаргах, нарийн мэргэжлийн чадварлаг зарчимч, шударга, үнэнч, мэргэшсэн албан хаагчдыг бүрдүүлж, үр дүнтэй, тогтвортой ажиллах орчин нөхцөлийг бүрдүүлэхэд оршино"[1] гэж шүүх шинжилгээний байгууллагын эрхэм зорилгоо тодорхойлсон ба энэ зорилгыг биелүүлэхэд хөдөө орон нутагт

[1] Цахим эх сурвалж. nifs.gov.mn

тулгамдаж байгаа асуудлууд их байна. Тулгамдаж байгаа асуудлуудыг ерөнхийлөн 3 ангилж авч үзлээ.

1. Эрх зүйн зохицуулалт ба байгууллагын үйл ажиллагаа
2. Сургалт, хүний нөөц;
3. Техник, технологи;

1. Эрх зүйн зохицуулалт ба байгууллагын үйл ажиллагаа. Засгийн газрын 270 дугаар тогтоолд /нутаг дэвсгэрийн нэгдсэн Эмнэлэг, Цагдаа/ "Дээрх байгууллагуудын криминалистикийн шинжээч, шүүх-шинжээч эмч, шинжээч эмч нарын орон тоо, төсөв болон криминалистикийн шинжээчдийн эзэмшиж, ашиглаж байгаа шинжилгээний аппарат, тоног төхөөрөмжийг тус тус балансаас балансад энэ оны 12 дугаар сарын 1-ний дотор багтаан Шүүхийн шинжилгээний албанд шилжүүлж, тухайн аймаг, дүүргийн цагдаагийн газар, хэлтсийн криминалистикийн лаборатори, ажлын контор, нэгдсэн эмнэлгийн задлан шинжилгээ, цогцос хадгалах өрөөг Шүүхийн шинжилгээний албыг ажлын байртай болох хүртэл төлбөргүй эзэмшүүлж байхыг Хууль зүй, дотоод хэргийн сайд Д.Одбаяр, Эрүүл мэндийн сайд Д.Туяа, Сангийн сайд Н.Баяртсайхан, Төрийн өмчийн хороо (Д.СУГАР), аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай.[1] Хэмээсэн нь одоо хүртэл энэ заалтыг хэрэгжүүлсээр явж байна хэзээ албаны өөрийн гэсэн байртай болох биеэ даасан цогц үйл ажиллагааг иргэдэд үзүүлэх орчинг бүрдүүлэх талаар хугацаагүй орхисон нь орон нутагт үйл ажиллагаа явуулахад олон хүндрэл бэрхшээл гарч байна.

Орон нутгийн албадын үйл ажиллагаа явуулж байгаа байрны эзэмшлийн талаар 2017 оны 02 сард зохион байгууллагдсан Шүүхийн шинжилгээний байгууллагын “Удирдах ажилтны нэгдсэн зөвөлгөөн"-ы үеэр албадын дарга нараас авсан санал асуулгаар цагдаагийн байранд 3. түрээсийн байранд 1, төрийн өмчит байранд 5, орон нутгийн өмчит байранд 7 тус тус үйл ажиллагаагаа явуулж байгаа нь Шүүхийн шинжилгээний албыг ажлын байртай болгох асуудлыг судалж, саналаа энэ оны 4 дүгээр улиралд багтаан Засгийн газарт танилцуулахыг Хууль зүй, дотоод хэргийн сайд Д.Одбаяр, Сангийн сайд Н.Баяртсайхан, Төрийн өмчийн хороо (Д.СУГАР)-нд тус тус даалгасугай.[2] хэмээсэн нь одоог хүртэл хэрэгжээгүй байна.

www.legalinfo.mn/

■ nifs.gov.mn хууль эрх зүйн акт булан

Хэргийн газрын үзлэг хийх, ул мөр, эд мөрийн баримт цуглуулах үйл ажиллагаа Монгол Улсын Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 17-р бүлэг буюу “Үзлэг. мөрдөн байцаалтын туршилт" гэсэн бүлгийн 126-р зүйлд

126.1.Хэрэг бүртгэгч. мөрдөн байцаагч гэмт хэрэг гарсаи байдал, хэргийн ул мөр. эд мөрийн баримтыг олох, гэмт хэрэгт ач холбогдол бүхий байдлыг тодруулах зорилгоор хэрэг гарсан газар болон эд зүйл, баримт бичигт үзлэг хийнэ.[1]

127 дугаар зүйл. Үзлэг хийх журмын 127.5.Үзлэг хийхэд уг хэрэгт хувипн сонирхолгүй мэргэжилтэнг урьж болно.[2]

Үзлэг хийх журмыг эрүүгийн байцаан шийтгэх хуулийн дөрөвдүгээр бүлэгт заагдсан Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаа явуулах төрийн байгууллага. албан тушаалтанууд хэрэгжүүлэх юм.

Шүүхийн шинжилгээний тухай хуулийн 37.1-т заасан 37.1 .Шүүхийн шинжилгээний байгууллага нь эрүү. иргэн. захиргааны болон бусад хэрэг. маргааныг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад нотлох баримтыг илрүүлж бэхжүүлж авах, ул мөр, эд мөрийн баримтад үзлэг, шинжилгээ хийж, шинжлэх ухааны үндэслэлтэй дүгнэлт гаргах чиг үүрэг бүхий төрийн байгууллага мөн.

Шинээр батлагдсан Цагдаагийн албаны тухай хуулийн 10.1.3-д “гэмт хэрэг. зөрчил гарсан тухай мэдээллийг хүлээн авмагц гэмт хэргийн газрыг хамгаалах, үзлэг хийх, нотлох баримт илрүүлэх, бэхжүүлэх, цуглуулах, гэмт этгээдийг олж тогтоох, эрэн сурвалжлах, баривчлах[3]” нь цагдаагийн байгууллагын чиг үүрэг байхаар хуульчилсан байна. Эдгээр хуулиар бол

1. Хэрэг бүртгэгч /хэсгийн төлөөлөгч/, мөрдөн байцаагч нар хэрэг гарсан газар үзлэг хийнэ;
2. Үзлэг хийхэд уг хэрэгт хувийн сонирхолгүй мэргэжилтэнг урьж болно;
3. Уригдаж очсон мэргэжилтэн нотлох баримтыг илрүүлж бэхжүүлж авна;

Эндээс үзэхэд үйл ажиллагааны энгийн дараалал, ойлгомжтой байдал харагдаж байна. Ийм л ерөнхий зохицуулалтаар олон жилийн турш явж ирсэн. Хэргийн газрын үзлэг хийх явцад бий болдог нарийн төвөгтэй олон үйл ажиллагаа тус хуулиудад нийцүүлэн боловсруулсан байгууллагуудын журам, заавраар зохицуулагддаг. Гэвч үнэн хэрэгтээ хуулийг хэрэгжүүлэн ажиллахаасаа илүүтэй тогтсон заншлаар явж иржээ.

[1] http://www.legalinfo.mn/law/details/59?lawid=59
[2] http://www.legalinfo.mn/law/details/59?lawid=59
[3] Төрийн мэдээлэл 2017.02.20 №08 /965/ 300 дахь тал

Өөрөөр хэлбэл. жижүүрийн мөрдөн байцаагч, жижүүрийн шинжээч хэргийн газар очиж хуулинд заасан нэр томъёоны дагуу "үзлэг" л хийж байна. Хэргийн газраас Ул мөр эд мөрийн баримтыг илрүүлж бэхжүүлж авах ажиллагааг тусгайлан Шүүхийн шинжилгээний байгууллагын Шинжээч, мэргэжилтнээр гүйцэтгүүлэх хуулийн зүйл заалт байхгүй ч уригдаж биш хуульчилсан юм шиг өнөө үед шинжээч, мэргэжилтнүүд ажиллаж байна.

2. Сургалт, хүний нөөц, эрүүл мэндийн чиглэлээр манай байгууллага Хууль зүйн сайдын эрхлэх асуудлын хүрээний "хөгжлийн стратеги хөтөлбөр 2008-2021-талба хаагчдыг ажлын байранд 3 жил тутамд мэргэшүүлэн сургана[1] гэсэн заалт байгаа энэ заалтын хэрэгжилт хараахан сайн хэрэгжихгүй байна. Орон нутгийн шинжээч мэргэжилтнүүд сургууль, курс төгсөөд давтан сургалт хийгдэхгүй байгаа нь ажлын бүтээмж муудах, хоцрогдох эрсдэл тулгарч байна. Иймд цахим сургалт хийх орчинг бүрдүүлвэл өртөг хямд хугацаа богино байх боломжтой юм. Мөн хүний нөөцийн нэгдсэн бодлого, төлөвлөгөө дутмаг явж ирсэн ба 2013 онд Цагдаагийн хэлтэсүүд 2, 3 хуваагдахад шинжээч, мэргэжилтэн дутмагаас тэтгэвэрт гарсан шинжээч нарыг буцаан ажиллуулах, шинээр курсын шинжээч бэлтгэн ажиллуулсан. Энэ нь шинжээч, мэргэжилтэний хүний нөөцгүй байсан нь харагдаж байна.

3. Техник, технологи. Хэргийн газрын мөрдлөг нь тактик, арга зүй, техник хэрэгсэл, ур чадвар шаардсан ажил. Үүнийг зарим талаар туйлшруулан ойлгож тусгай зориулалтын техник, хэрэгсэл гадаадаас авчрахгүй л бол болохгүй байна гэсэн санаа бодол хуулийн байгууллагын бүх түвшинд оршсоор байдаг.Техник хэрэгслийн хангалтыг хэргийн газрын үзлэгт нэг удаа ч оролцож байгаагүй дарга, нягтлан бодогч, нярав зэрэг албан тушаалтнууд хийж байдаг нь харамсалтай. “Миний тухай асуудлыг надгүйгээр бүү шийд” гэсэн үг байдаг.[2] Өнөөдөр манай байгууллагуудад огт хэрэглээгүй эд зүйл байна, ганцхан хэрэглээд хэрэглэх боломжгүй болсон эд зүйлүүд гэж байна эдгээр нь тус бүрдээ их хэмжээний үнтэй эд зүйлүүд байх юм би үүний дээр дурьдсантай санал нэгтгэж авч үзэж санаа нэг байгаагаа илэрхийлж байгаа юм.

[1]хууль зүй дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээний “хөгжлийн стратеги хөтөлбөр” 2008-2021 81 дэх тал

[2]Монголын шүүх шинжээчдын холбоо-ны албан ёсны сайт http://mongolianforensics.blogspot.com Тогоохүүгийн Очирбат “хэргийн газрын үзлэг буюу хэргийн газарт хийх мөрдлөгийн цогц ажиллагааг бий болгох асуудал" өгүүллэгийн 5 дахь хуудас

1. Орон нутгийн Шүүхийн шинжилгээний албадыг шаардлагатай орон тоо. материаллаг баазаар хангаж, үйл ажиллагааг нь тогтворжуулан бэхжүүлэх.

3. Шинжээч. мэргэжилтэний хүний нөөцийн цогц бодлого боловсруулах.

2. Албуудыг үйл ажиллагаагаа явуулахад стандартын шаардлага хангасан байртай болгох тал дээр анхаарах төрөөс нэгдсэн бодлогоор дэмжих.

3. Байгууллагын үйл ажиллагааг цогц болгохын тулд эрх зүйн зохицуулалтуудыг сайжруулах арга хэмжээ авах

4. Шуурхай удирдлагын автомашинаар нэгдсэн журмаар хангуулах, түлш шатахууны төсвийг суулгах, хэргийн газрын үзлэгийн техник хэрэгсэл. төхөөрөмжийг шинэчлэх.

6. Манай байгууллага хууль зүйн сайдын эрхлэх асуудлын хүрээний “хөгжлийн стратеги хөтөлбөр 2008-2021”-т алба хаагчдыг ажлын байранд 3 жил тутамд мэргэшүүлэн сургана [1] гэсэн заалт байгаа энэ заалтын хэрэгжилт хараахан сайн хэрэгжихгүй байна. Иймд цахим сургалт орох орчинг бүрдүүлвэл өртөг хямд хугацаа богино байх боломжтой юм.

***Ж.Тамир*** *-Хууль сахиулахын удирдлагын академийн 821 дүгээр дамжааны суралцагч, цагдаагийн ахлах дэслэгч*

## ЭРҮҮГИЙН БАЙЦААН ШИЙТГЭХ АЖИЛЛАГАА ДАХЬ ШҮҮХИЙН ШИНЖИЛГЭЭНИЙ БАЙГУУЛЛАГЫН УДИРДЛАГЫН ЭРХ ЗҮЙН БАЙДЛЫН ЗАРИМ АСУУДАЛ

***Хураангуй.*** *Энэхүү илтпгэлээр эрүүгийн байцаан ишийтгэх ажиллагаа дахь шүүхийн шинжилгээний байгууллагын удирдлагын эрх зүйн байдлын өнөөгийн байдал, эрх үүргээ хэрэгжүүлэхэд үүсч буй зарим асуудал, түүнээс гарах арга замыг эрэлхийлэхийг зорилоо.*

***Түлхүүр үг.*** *Шүүхийн шинжилгээний байгууллагын удирдлага, эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаа, ишнжээчийн дүгнэлт, шинжилгээний магадлагаа, мэргэжилтний дүгнэлт, тусгай мэдлэг, тусгай чадвар*

Манай Улсын хувьд 2009 онд Шүүхийн шинжилгээний байгууллага нь бие даасан хуультай болсон бөгөөд энэхүү өөрчлөлтөөр эрхзүйн байдлын хувьд олон талын дэвшил гарсан гэж судлаачид үздэг боловч шүүхийн шинжилгээний байгууллагын удирдлагын эрүүгийн байцаан шийтгэх

[1] хууль зүй дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээний “хөгжлийн стратеги хөтөлбөр"’ 2008-2021 81 дэх тал